



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/139

Улаанбаатар хот

“Өсвөрийн аврагч” тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2.3, 13.3.6 заалтууд, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр” 303 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг, чадварыг олгох зорилгоор “Өсвөрийн аврагч” тэмцээнийг 2017 оны 05 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсугай.

2. “Өсвөрийн аврагч” тэмцээн зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, тэмцээнд оролцох сурагчдад гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээний бэлтгэл ажлыг бүрэн хангуулан өндөр түвшинд зохион байгуулахыг Онцгой байдлын хэлтэс /Л.Цэрэндаваа/, Боловсролын хэлтэс /Х.Батбаяр/, Улаан загалмайн хороо/Д.Жавзмаа/ нарт тус тус даалгасугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Баясахад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВДАВАА